



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 06 сарын 24 өдөр

Дугаар А/336

Хэрлэн сум

Сувилагч, мэргэжилтнүүдийг сувилалд
сувилуулахад зориулж хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.5, 11.1.7, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Коронавируст (Ковид-19) халдварын тархалтын үед сэтгэл, зүтгэл гарган үр бүтээлтэй ажилласан сувилагч, тусгай мэргэжилтнүүдийг сувилалд сувилуулахад шаардагдах шатахууны зардалд 938,350 (есөн зуун гучин найман мянга гурван зуун тавь) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2.Зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

3.Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн байгууллага, иргэдээс тавьсан хүсэлтийг шийдвэрлэх зардлаас олгохыг Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2022 оны
06 дугаар сарын 29-ны
дугаар захирамжийн хавсралт

Шатахууны зардлын задаргаа

№	Зардлын төрөл	Нэг бүрийн үнэ	Хэмжээ	Нийт үнэ
1.	Дизель	3830	245 л	938,350
2.		Нийт		938,350

Жич: Сувилалд автобусаар явахаар төлөвлөж, 100 км-д 35 л-ийг зарцуулахаар тооцов.